

СҮХБААТАР АЙМГИЙН СҮХБААТАР СУМ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 2 ДУГААР САРЫН МЭДЭЭ

Төрийн удирдлагын чиглэлээр:

2022 оны 02-р сарын 10, 11-ний өдрүүдэд Аймгийн "Удирдах ажилтны зөвлөгөөн зохион байгуулагдаж Засаг дарга нар 2021 онд хэрэгжүүлэсэн ажлын тайлан, 2022 онд хийхээр төлөвлөсөн арга хэмжээний талаарх мэдээллийг танилцуулсан. 2021 оны үйл ажиллагаагаар сум аймгийн хэмжээнд 2-р байрт шалгарсан. Аймгийн Засаг дарга, сумын Засаг дарга нартай 2022 онд хамтран ажиллах гэрээ байгууллаа.

Байгаль орчин , Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Хөдөө Аж ахуйн салбарт он удаан жил амжилт бүтээл гаргаж 2018-2020 он буюу сүүлийн гурван жилийн ажлын үзүүлэлтээрээ бусдыгаа манлайлсан Улсын аварга малчин 1, Аймгийн сайн малчин 3, Сумын сайн малчин 15 болон мянгат малчид 20, тус тус тодорсон.

1-р сарын 31 өдөр Улсын Аварга малчин болсон 4-р багийн малчин Б.Хатанбаатарын шагналыг гардуулахаар УИХ гишүүн Ганибал, Аймгийн ИТХ дарга Хосбаяр нар ажлын хэсгийн хамт малчны хотонд очиж гардуулсан.

1-р сарын 25 өдөр аймгийн сайн малчин болсон 1-р багийн малчин Г.Баярсүрэн, О.Болдхүү, Ц.Цэвээндорж нарт шагнал гардуулахаар Аймгийн Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлогийн даргаар ахлуулсан ажлын хэсэг ирж малчны хотонд шагналыг гардуулсан.

1-р сарын 30 өдөр МҮОНРТ-ын Алтан төлийн эзэд болсон 1-р багийн малчин Л.Лхагва, 4-р багийн малчин Б.Үнэнбат , 4-р багийн малчин Ш.Мижиддорж нарт Улсын их хурлын гишүүн Ганибал даргаар ахлуулсан ажлын хэсэг малчны хотонд очиж шагнал гардуулсан

Тэр бум үндэсний хөдөлгөөний хүрээнд аймагт болсон чуулга уулзалтад Засаг дарга, ИТХ-ын, Байгаль орчны улсын байцаагч нар оролцож аймаг, сумын хэмжээнд тэр бум мод хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх хамтын ажиллагааны гэрээг байгуулсан.

Тус сумын 1 р багийн нутаг гуя, бухт орчимд хууль бус ашигт малтмал хайгч нинжаа нар байна гэсэн мэдээллийн дагуу тус газар 2 удаагийн эргүүл хяналт шалгалтыг хийж хэрэгжүүлж ажилласан.

Сар шинийн баярын өдрүүдэд Дархан хаан уулыг зорих сүсэгтэн олон аялагчид ихээр ирж тус газар хог хаягдал хаях зэрэг зөрчил гарч байсныг тухайн бүр ЗДТГ-аас томилогдсон албан хаагч нар цэвэрлэх ажлыг 3 удаа хийж, 37 шуудай хогийг нэгдсэн цэгт асгаж шатаасан

1,2-р саруудад гоц халдварт шүлхий өвчний дэгдэлттэй байна. Сумын засаг даргын 2022.01.20 –ны өдрийн А/07 тоот захирамжаар 5-р багийн нутаг “Мурийн говь”-д Баруун-Урт сумын 8-дугаар багийн малчин Б Энхтөрийн суурьт шүлхий өвчин, үхэрт гарсантай холбогдуулж хорио цээрийн дэглэмтэй ажиллаж байна. Мөн сумаас амьд мал түүхий эд бүтээгдэхүүн гадагш гаргахыг хориглон гарал үүслийн бичиг олгохгүй байгаа. 2022 онд хийгдэх ажлын талаар төлөвлөгөө боловсруулан цахим системд суулгах ажил хийгдээд явж байна.

Эрүүл мэнд, Боловсролын чиглэлээр:

Эрүүл мэндийн төв:

Хэвтэн эмчлүүлэгч – 19

Ор хоног – 135

Нийт үзлэг- 598

Түргэн тусламжийн дуудлага - 45

Алсын дуудлага – 23

Гэрийн дуудлага- 22

Осол гэмтлийн дуудлага - 0

Нас баралт – 2

Ковидын вакцины нэмэлт тунгын хүрээнд дархлаажуулалт 1-р тун 12 хүн, 2-р тун 5, хүн 3-р тун 10 хүн, 4-р тун 85 хүн

✓ Сурагчдын амралт дуусаж хичээл эхлэх болсонтой холбогдуулан сургуулийн анги танхим, дотуур байр, гал тогоонд халдваргүйжүүлэлт, ариутгалыг хийсэн.

✓ Дотуур байрын сурагчдын ор хөнжлийн цагаан хэрэглэл, дэвсгэрийг угааж цэвэрлэн, агаарт гарган тусгай ариутгагч аппаратаар ариутгасан.

✓ Цаг агаар хүйтэрснээс сургуулийн 00-ын гадна хоолой хөлдөж ариун цэврийн өрөөг ашиглах боломжгүй болсон. Хөлдсөн хоолойг ухаж гаргах, хуучин бохирын цооног руу нь холбох ажлыг хийж байна.

✓ Их цэвэрлэгээг 7 хоногт 1 удаа хийж байна.

✓ Ерөнхий боловсролын сургууль нь аймгийн Боловсролын газрын тоон болон чанарын үнэлгээгээр аймагтаа “Гутгаар” байр эзэлж 2021 оны ажлаа амжилттай үнэлүүлсэн.

✓ Ковидын халдвараас сэргийлэх дархлаажуулалтын 4-р тунд Цэцэрлэгийн 25-20 багш, ажилчид хамрагдсан. /Хийлгэхгүй заалттай-1, Жирэмсэн-2, 3-р тун хийлгээд хугацаа болоогүй-2/ Бүлгийн багш, туслах багш болон гал тогооны ажилчдаас түргэвчилсэн шинжилгээ авсан бүгд сөрөг гарсан.

✓ 7 хоног бүрийн баасан гаригт Цэцэрлэг анги танхим өрөө тасалгаанд их цэвэрлэгээ хийж ариутгал халдваргүйтгэл хийдэг.

✓ Монгол улсын БШУС-ын 2022 оны 02 дугаар сарын 09 ны өдрийн А/38 тушаалын дагуу 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс сургалт үйл ажиллагааг 100% танхимаар явагдах болсонтой холбоотой цэцэрлэгийн 3-настай 30 хүүхдийг нэмж бүртгэж эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд бүрэн хамруулсан.

Соёл урлагийн чиглэлээр:

1. “Монгол улсын жишиг соёлын төв”-д батламж гардуулах ёслол “Сайжруулагч” хэмээх усан бар жилийн битүүний өдөр цахимаар зохион байгуулагдаж, Соёлын дэд сайд М.Батбаяр, Аймгийн засаг дарга М.Идэрбат, Аймгийн соёлын урлагийн газрын дарга Х.Эрдэнэдэлгэр, ахлах мэргэжилтэн Б.Золхүү, соёл урлагийн

газрын хамт олон, Сүхбаатар сумын засаг даргын орлогч Р.Биндэръяа, засаг даргын зөвлөх Ц.Ган-Өлзий, Жишиг соёлын төвийн хамт олон оролцон, Монгол улсын жишиг соёлын төвийн батламжаа цахимаар гардан авлаа.

2. Монгол улсын жишиг соёлын төвийн үйл ажиллагааг олон нийтэд танилцуулах зорилгоор Сүхбаатар аймгийн BBS телевизийн мэдээллийн хөтөлбөрт соёлын төвийн дарга Л.Батжаргал уригдан оролцож, байгууллагын үйл ажиллагаагаа сурталчилсан.

3. "Сайжруулагч" хэмээх усан бар жилийн **"ШАШИН УРЛАГИЙН ЦЭНГҮҮН"**-ийг амжилттай зохион байгуулсан. Нийтээрээ буян хураах шашин урлагийн цэнгүүнд Сүхбаатар аймгийн бурхан шашинтны төв Эрдэнэмандал хийд, Өмнөд Энэтхэгийн "Гомбо" дацангийн лам хуврагууд, Сүхбаатар сумын Мөнхэрдэнэномунхан хийдийн лам хуврагууд оролцсон. Соёлын төв нь тус арга хэмжээний урлагийн тоглолтыг 12 хүний бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулан, лед контент, тайз засалт зэрэг бэлтгэл ажлыг ханган ажиллаж танхимаар **200** хүнд хүргэсэн. Мөн нийтээрээ буян хураах "Дүнчүүр маань" хөгжөөсөн.

4. Сүхбаатар сумын соёлын төв нь аймгийн Соёл урлагийн газрын 2021 оны тоон болон чанарын үнэлгээгээр амжилттай үнэлэгдэж "Тэргүүн" байр хүртэж, соёлын төвийн дарга Л.Батжаргал соёлын төвийнхөө орчин нөхцөл, үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, улс бүсийн чанартай уралдаанд удаа дараа амжилттай оролцон, Сүхбаатар аймгийн 2021 оны "ТЭРГҮҮНИЙ МЕНЕЖЕР"-ээр тус тус шалгарч 2022 оны 02 сарын 21-ны өдөр Сүхбаатар аймгийн Соёлын урлагийн газрын нээлтийн үйл ажиллагаан дээр шагналаа гардан авлаа.

5. Цахим орчин 24 мэдээ мэдээлэл нийтэлж **367** хүнд, Танхимаар 2 тоглолт зохион байгуулж **270** хүн, нийтдээ **637** хүнд соёл урлагийн арга хэмжээгээр үйлчиллээ.

МЭДЭЭ ГАРГАСАН :

Хууль, эрх зүйн мэргэжилтнийг түр орлон гүйцэтгэгч:

Э.Дэлхийцэцэг

ХЯНАСАН:

Засаг даргын Тамгын газрын дарга

/Ц.Сүхболд/